



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/34

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Сумын 2022 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Усан хангамжийн системийг алсын горимд оруулах” ажлын санхүүжилтэд 4,482,378 (дөрвөн сая дөрвөн зуун наян хоёр мянга гурван зуун далан найм) төгрөгийг зарцуулсугай.

2. “Усан хангамжийн системийг алсын горимд оруулах” ажлын санхүүжилтэд зарцуулагдах 4,482,378 (дөрвөн сая дөрвөн зуун наян хоёр мянга гурван зуун далан найм) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П. ГАНЧИМЭГ



421220121